



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 122

Эрдэнэт

Итгэмжлэгдсэн төлөөлөгч нарыг  
томилох тухай

Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, 27 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 28.2-д заасныг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орхон Аймаг Дахь Захиргааны Хэргийн Анхан Шатны Шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 10 дугаар шийдвэр, түүнд өөрчлөлт оруулсан Захиргааны Хэргийн Давж Заалдах Шатны Шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 221/МА2016/0436 магадлалтай хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулах анхан болон, давж заалдах, хяналтын шатны шүүхүүдэд Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг бүрэн төлөөлөх эрхийг Чойжилын Оюунгэрэл /ФБ67021506/, Чогсомжавын Энхболд /ЧИ77042773/ нарт олгож, 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаагаар итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

2. Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 7 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх, Орхон аймгийн иргэдийн сонгох, сонгогдох эрх зөрчигдөх үндэслэл бий болох нөхцөл байдал үүсэж болзошгүй байгааг харгалзан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Орхон аймаг дахь Захиргааны Хэргийн Анхан Шатны Шүүхэд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дээрх шүүхийн шийдвэрүүдийг дахин хянуулахаар нэхэмжлэл гаргахаар тогтоосугай.

3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д зааснаар итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт нэхэмжлэлд гарын үсэг зурах, хариу тайлбар гаргах, нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх нэхэмжлэлийн шаардлагаас бүрэн эсхүл хэсэгчлэн татгалзах, нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх, ихэсгэх эсхүл багасгах, эвлэрэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлийг бусдад шилжүүлэх, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлт гаргах бүрэн эрхийг олгосугай.



ДАРГА  П.ПҮРЭВЛХАГВА